



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 62


Баян-Өндөр сум

“Иргэдийн санаачилгыг дэмжих  
хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэдийн санаачилгыг дэмжих хөтөлбөр”-ийн 4.7 дахь заалтад “Хөтөлбөрийг иргэдэд сурталчлан таниулах ажлын зардалд тус хөтөлбөрөөс 3 хүртэл хувийг санхүүжүүлж болно”, 6.2 дахь заалтад “Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн орцны засвар болон хувь хүний эзэмшлийн бүсэд санхүүжилт хийхийг хориглоно” гэсэн заалтыг тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

ДАРГА



Э.ЭРДЭНЭБАТ